



“БОГД БАНК ХК-ЫН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮН ЖАМБАЛСҮРЭН ОВОГТОЙ НАРАНТУЯАГИЙН 2023 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ТАЙЛАН”

Миний бие Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн, Нэр дэвшүүлэх, үнэлгээ урамшууллын хорооны дарга, эрсдэл болон аудитын хорооны гишүүнээр ажиллаж байна.

/ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРМЫН 5.2.1, 5.2.2/

Тайлант хугацаанд компанийн тухай хууль, банкны тухай хууль, Богд банкны ТУЗ-ийн үйл ажиллагааны журмын дагуу

- Төлөөлөн удирдах зөвлөлийн нийт 32 удаагийн,
- Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хорооны 2 удаагийн хуралд оролцсон. Мөн 2023 оны аудитын төлөвлөгөөнд багтсан Мөнгө угаалт, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагааны аудитын хүрээнд ТУЗ-аас баталсан Дотоод хяналтын хөтөлбөрт ямар чиглэлээр аудит талаар санал өгсөн,
- Төлөөлөн удирдах зөвлөлийн эрсдэлийн удирдлагын хорооны 4 удаагийн,
- Нэр дэвшүүлэх үнэлгээ урамшууллын хорооны 2 удаагийн ээлжит болон ээлжит бус хуралд оролцож тогтоолын төсөл болон хэлэлцсэн асуудалд саналаа өгч ажилласан. Дээрх хурлуудаар хэлэлцүүлж байгаа асуудалтай танилцаж, саналаа өгөхдөө Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, бусад хууль тогтоомжийг баримтлан хараат бус гишүүний хувьд шийдвэр гаргалтад оролцсон ба зарчмын зөрүүтэй санал байгаагүй.

ТУЗ-ийн дэргэдэх эрсдэл болон аудитын хорооны хуралд гишүүний хувиар оролцон дараах асуудлуудад саналаа өгч, шийдвэр гаргахад оролцсон болно.

ТУЗ-ийн дэргэдэх эрсдэлийн хорооны хурал			
1	2023.01.20	23/01	1. Эрсдэлийн аппетит - 2023 2. Чанаргүй активыг бууруулах стратеги - 2023
2	2023.04.14	23/02	1. Богд банк ХК-ийн тогтвортжуулах төлөвлөгөөг батлах тухай
3	2023.05.26	23/03	1. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд чиглэсэн дотоод хяналтын хөтөлбөр болон эрсдэлийн удирдлагын хөтөлбөр танилцуулах 2. Эрсдэлийн аппетитийн гүйцэтгэл
4	2023.06.09	23/04	Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл олгож Түрээсийн гэрээ байгуулах тухай

ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал			
1	2023.02.08	23/01	1. ДАГ-ын 2022 оны ажлын тайланг хэлэлцэх тухай 2. Богд банкны 2023 оны ДАГ-ын төлөвлөгөө батлах тухай
2	2023.05.22	23/02	1. ДАГ-ын дүрэм, бодлого, журмыг шинэчлэн батлах тухай 2. ДАГ-ын төлөвлөгөөний явц 3. Банкны 2023 оны 1-р улирлын санхүүгийн үзүүлэлтүүд



ТУЗ-ийн нэр дэвшүүлэх үнэлгээ урамшууллын хорооны даргын хувьд тайлант хугацаанд дараах 2 удаа хорооны хурлыг хуралдуулах шийдвэр гаргаж хурлаар хэлэлцэх асуудлыг баталж гишүүдэд танилцуулан ажилласан байна. Үүнд:

ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ НЭР ДЭВШҮҮЛЭХ, ҮНЭЛГЭЭ УРАМШУУЛЛЫН ХОРООНЫ ХУРАЛ			
1	2023.02.06	23/01	Гүйцэтгэх захирал Г. Саруулын 2022 оны ажлын гүйцэтгэлийг дүгнэх тухай
2	2023.03.10	23/02	Компанийн ТУЗ-ийн гишүүнийг чөлөөлж, шинээр ТУЗ-ийн гишүүнийг сонгох тухай

Хорооны хурлуудад зарчмын зөрүүтэй санал гараагүй бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь компанийн эрх ашигт сөргөөр нөлөөлөгүй, үйл ажиллагаа нь хууль тогтоомж, дүрэм, журамд нийцэж ажилласан.

/ХАРААТ БУС ГИШҮҮНИЙГ НЭР ДЭВШҮҮЛЭХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ ЖУРМЫН 5.2.3/

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.17 дахь заалтын дагуу сонирхлын зөрчилтэй 5 удаагийн хэлцэлд оролцож өөрийн саналыг өгч, сонирхлын зөрчилтэй хэлцлийг тухайн асуудалд ашиг сонирхлын зөрчилгүй гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэж ажилласан.

Сонирхлын зөрчилтэй хэлцэлийн жагсаалт			
1	2023.02.01	23/06	Сонирхлын зөрчилтэй хэлцэл баталж Кредит картын эрхийг нэмэгдүүлэх тухай
2	2023.03.17	23/32	Сонирхлын зөрчилтэй хэлцэл баталж зөвлөх үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулах тухай
3	2023.04.05	23/37	Сонирхлын зөрчилтэй хэлцлийг баталж зээл олгох тухай
4	2023.04.05	23/28	Сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулах зөвшөөрөл олгож Түрээсийн гэрээ байгуулах тухай
5	2023.05.11	23/53	Сонирхлын зөрчилтэй хэлцэл баталж зээл олгох тухай


ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ХУВЬД:

Богд банк ХК нь Монгол улсын Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох Монголбанкны дүрэм журмын дагуу банкны засаглалыг хэрэгжүүлэн хангалттай сайн ажиллаж байна. Удирдлагын баг, ТУЗ-ын гишүүд, Хувьцаа эзэмшигчдийн хооронд харилцааны үл ойлголцол байхгүй, банкны шийдвэр гаргалт нэг албан тушаалтны хэт төвлөрөлгүйгээр зохих журмын дагуу явагдаж байна.

Заавал мөрдөх ёстой аливаа хууль, дүрэм журмыг зөрчсөн болон харилцагч, хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт сөргөөр нөлөөлөхүйц шийдвэр, үйлдэл банкны үйл ажиллагаанд гараагүй болно.

Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журмын 5 дугаар зүйлийн 5.1-т заасны дагуу 2023 оны эхний хагас жилийн тайланг бэлдэн хүргүүлэв.

Богд банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн
2023.07.04


/Ж.Нарантуяа/